

ТАНИЛЦУУЛГА

Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлын 2009 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Шүүхийн шинжилгээний тухай” Монгол улсын хууль батлагдсанаар шүүхийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах процессыг бие даасан хуулиар зохицуулах болсон. Тус хуулиар улсын хэмжээнд шүүхийн шинжилгээ явуулах нийтлэг журам, зарим төрлийн шинжилгээ хийх онцлог болон Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, шинжээчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж байна.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийг дагаж мөрдөөд 10 гаруй жил өнгөрсөн ба нийт 6 удаа, давхардсан тоогоор 40 гаруй зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орж хуулийн анхны бичвэрээс олон зүйл, заалт өөрчлөгдсөн байна. Эдгээр өөрчлөлтийн тухайд уг хуулийн агуулга, үзэл баримтлал, процессын зохицуулалтуудыг өөрчлөхөд бус, харин бусад процессын хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан хийгдсэн байдаг. Уг нэмэлт, өөрчлөлтүүдээр хуулийн зүйл, заалт, хэсгийн логик уялдаа холбоо алдагдах, нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, зарим нэр томъёог өөр өөрөөр томъёолсон, мөн зарим зохицуулалт хангалттай бус хэвээр байна.

Түүнчлэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурлаас Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг тус тус баталсантай холбогдуулан шүүх эрх мэдлийн болон хууль хяналтын байгууллага хоорондын чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг шинээр авч үзэх, шүүх шинжилгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага гарсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050”¹ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт шүүхийн шинжилгээний эрх зүйн орчныг нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, салбарын үйл ажиллагаанд шинжлэх ухааны өндөр түвшний технологийг нэвтрүүлэх бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, судалгаа, шинжилгээний баазыг бэхжүүлэх, байгууллагын техник, тоног төхөөрөмж болон хүний нөөцийн чадамжийг дээшлүүлэхээр заасан болно.

Түүнчлэн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн² 57-д хүн амын тоо, нягтрал, гэмт хэргийн гаралт, шүүхийн шинжилгээний хэрэгцээ, цар хүрээ, шинэ төрлийн болон тусгай шинжилгээний шаардлага зэргийг харгалзан шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоог өөрчилж, бүтэц, бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэн эрх зүйн статусыг тодорхой болгох, шинэ төрлийн шинжилгээний зохицуулалт, итгэмжилсэн шинжээчийн эрх зүйн орчин, шүүхийн шинжилгээ хийх үндэслэл, журам, шинжилгээний онцлог, зарим төрлийн хохиролд үнэлгээ тогтоохтой холбоотой зохицуулалтыг бий болгох зорилтыг дэвшүүлсэн.

¹ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 54 дүгээр тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхтгэл 2020 оны №25,

² Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхтгэл 2021 оны №11

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн³ 4.3.7-д “Шүүхийн шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шүүхийн шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангана” гэж заасан байна.

Дээрх үндэслэл, шаардлагад үндэслэн Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулав.

Шүүх шинжилгээний тухай хуулийн төслийн зорилтыг шүүх шинжилгээ хийх, хүрээлэн байгаа орчны хохирол болон сэтгэцэд учирсан хор уршгийн зэргийг тогтоох, нөхөн төлөх төлбөрийг тогтоох, шүүх шинжилгээ хийх эрх олгох үндэслэл, журам болон шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршихоор тодорхойлж, хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээг хуулийн төсөлд дараах байдлаар тусгалаа. Үүнд:

1.Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуулийн нэр томъёотой нийцүүлж, шинээр нэмж томъёолох хүрээнд;

-Шүүхийн шинжилгээний тухай хуульд нийт 6 удаа, давхардсан тоогоор 40 гаруй зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орж хуулийн анхны бичвэрээс олон зүйл, заалт өөрчлөгдсөн. Тухайлбал, Эрүүгийн хууль 2015 онд, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 онд, Цагдаагийн албаны тухай хууль 2017 онд тус тус шинэчлэн батлагдан тодорхой өөрчлөлтийг оруулсан.

-Гэсэн хэдий ч эдгээр өөрчлөлтийн тухайд уг хуулийн агуулга, үзэл баримтлал, процессын зохицуулалтуудыг өөрчлөхөд бус, харин оруулсан нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан хийгдсэн байдаг. Зарим нэр томъёо өөр өөрөөр тодорхойлогдсоныг нэг мөр болгосон.

-Нөгөө талаар шүүхийн шинжилгээг чанартай, хурдан шуурхай шинжлэх ухаанч байдлаар хийх хүрээнд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан нэр томъёог жигдэлж, шүүх шинжилгээ хийх нийтлэг журмыг тодорхойлох, шинжээчийг томилох, хугацааг сунгах, шинжилгээний дүгнэлтийг гаргах зэрэг уг харилцааг зохицуулсан голлох зохицуулалтыг Шүүх шинжилгээний тухай хуулийн төсөлд нэгтгэн нарийвчлан тусгаж, харин процессын хуулиудад дээрх хуулийг эшлэх байдлаар тусгасан бөгөөд зөрүүтэй байсан нэр томъёог жигдэлсэн болно.

2.Шүүх шинжилгээний нийтлэг журмыг боловсронгуй болгож, шинжилгээний хугацааг жишиг хугацааг үндэслэн тогтоох, хялбар байдлаар хугацааг сунгах эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд;

Шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэхэд нөлөөлөх нэг хүчин зүйл нь шинжилгээ хийж, дүгнэлт гаргах хугацааны асуудал юм.

³ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхтгэл 2020 оны №38.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно” гэж заасан ч шинжээчийг томилж байгаа этгээд шинжилгээний төрөл, хэлбэр, онцлог, цар хүрээ, объектын тоо хэмжээ зэргийг харгалзан үзэхгүй байгаа нь шинжилгээ хийх үйл ажиллагаанд хүндрэл учруулж, шинжилгээний үр дүнд сөргөөр нөлөөлөхөөр байна.

Шинжилгээ хийлгэж байгаа мөрдөгч, прокурор, шүүгч, шүүх болон хуульд заасан эрх бүхий этгээдийн зүгээс бүх төрлийн шинжилгээг хийх хугацааг 3-5 хоногийн хугацаатайгаар тогтоож байгаа нь нэг талаас эдгээр субъектэд шинжилгээ хийх хугацааг тогтоох давуу эрхийг хуулиар олгосонтой холбоотой.

Нөгөө талаас шинжилгээ хийх хугацааг тогтоохдоо шинжилгээний байгууллагаас хүргүүлсэн жишиг хугацааг харгалзан үзэх тухай хуульд нарийвчилсан зохицуулалт байхгүй. Иймд шинжилгээг хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээг хийх хугацааг тогтоохдоо тухайн шинжилгээний төрөл, цар хүрээ, объектын тоо хэмжээ, онцлогийг харгалзан шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон шинжилгээ хийлгэх жишиг хугацааг үндэслэж байхаар хуулийн төсөлд заасан болно.

Харин хугацаа сунгах асуудлыг шинжилгээний байгууллагын шинжээчийн хүсэлтийг үндэслэн дээд шатны албан тушаалтан сунгаж, энэ тухай шүүх, прокурор, мөрдөн байцаагч, эрх бүхий этгээдэд (мэргэжлийн хяналтын улсын байцаагч) мэдэгдэхээр зохицуулсан.

Шинжилгээний байгууллагаас гадуур хийх шинжилгээний хугацааг шүүх, прокурор, мөрдөн байцаагч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч сунгахаар зохицуулалтыг төсөлд тусгасан.

3.Шүүх шинжилгээний хэлбэр, төрлийг шинээр тодорхойлж, шинжилгээний адилтгал, мэдээллийн сан, түүний төрөл, бүрдүүлэлт, ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх хүрээнд;

Шүүх шинжилгээний хэлбэрийг анхдагч, давтан шинжилгээ, багаар хийх шинжилгээ зэргээр ангилал, төрлийг тодорхой болгож, тус бүрийн онцлогийг харуулсан зохицуулалтыг төсөлд тусгасан.

Түүнчлэн шинжилгээний адилтгал, мэдээллийн сан, түүний төрөл, ашиглалт, хамгаалалттай холбоотой харилцааг нарийвчлан хуулийн төсөлд тусгасан. Тухайлбал, шүүхийн шинжилгээ адилтгал, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ашиглах хамгаалах зохицуулалтыг шинжилгээний адилтгал, мэдээллийн төрөлжсөн сангийн зохицуулалтыг тухайн мэдээллийн сангийн ашиглалт, бүрдүүлэлтийн ялгаатай байдлаар тусгасан болно.

4.Шүүх шинжилгээний байгууллагад болон бусад этгээдээр хийлгэх шинжилгээг тодорхойлж, шинжилгээний байгууллагаас бусад этгээдийг шүүх шинжилгээний сургалтад хамруулах, тэдэнд шинжээчийн эрх олгох, түдгэлзүүлэх, хасахтай холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд;

Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад

нотлох баримтыг илрүүлэн бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүргийн хүрээнд улсын хэмжээнд шүүхийн шинжилгээг хийж, дүгнэлт гаргах ажиллагааг хэрэгжүүлж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагад хийгдэж байгаа шинжилгээний тоон үзүүлэлт жил тутам өссөөр байна.

Шүүхийн шинжилгээний хүрээлэнд хийгдсэн хими, физик, биологийн шинжилгээний тоо								
Он	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Тоо	11629	13551	13894	13894	14002	15814	14696	16439

Шүүхийн шинжилгээний байгууллага нь бүх төрлийн шинжилгээг хийх боломжгүй тул зарим төрлийн шинжилгээг шинжилгээний байгууллагаас бусад мэргэшсэн тусгай мэдлэг бүхий хүн, хуулийн этгээдээр хийлгэх зохицуулалт шаардлагатай байх тул энэ талаарх зохицуулалт болох шинжилгээний байгууллагаас бусад этгээдээр шинжилгээ хийлгэхэд тавигдах шаардлага, шинжилгээ хийх эрх олгох, түдгэлзүүлэх, сунгах, хүчингүй болгохыг хуулийн төсөлд нарийвчлан тусгасан.

Ингэснээр төрийн байгууллагын тодорхой төрлийн ачаалал, зардал багасах, мэргэшсэн тусгай мэдлэг бүхий мэргэжилтэн зарим шинжилгээг хийх нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Түүнчлэн хуулийн төсөлд шүүх шинжилгээний байгууллагаас бусад шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр шинжилгээг хийхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгасан. Тухайлбал, дээрх этгээд нь шинжилгээ хийх бол Шүүх шинжилгээний тухай хууль тогтоомжид заасан шинжилгээний нийтлэг журам болон тусгай журмыг баримтлан хийх, мөн шүүх шинжилгээний байгууллагын шинжээчийн нэг адил шинжээчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд шинжээчийн шинжилгээ хийхэд саад учруулсан, хараат бус байдалд нөлөөлсөн, нөлөөлөхийг завдсан тохиолдолд шинжээч нөлөөллийн мэдүүлэг гаргаж, дээд шатны удирдлага, эсхүл холбогдох байгууллагад мэдэгдэх үүргийг чухалчлан тусгасан.

5.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны явцад хийх шинжилгээний зарим онцлог зохицуулалт болох инженер-техникийн шинжилгээ, хөрөнгийн үнэлгээнд хийх шинжилгээ, цахим технологийн шинжилгээ хийх зохицуулалт, журмыг шинээр тусгах хүрээнд;

Шүүхийн шинжилгээний тухай хуульд эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын болон зөрчлийн хэрэг, маргаанд хийгдэж байгаа зарим төрлийн шинжилгээний онцлогийн талаар тусгаагүй бөгөөд нийгмийн хөгжлийг даган инженер техникийн шинжилгээ, хөрөнгийн үнэлгээний шинжилгээ, цахим технологийн шинжилгээ зэрэг тусгай мэдлэг шаардагдах шинжилгээ, үнэлгээг хийх талаарх зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах шаардлага тулгарч байна.

Үүний хүрээнд тухайн шинжилгээний нийтлэг журам, шинжилгээг хийхэд тавигдах шаардлага, байгууламж, объектод тавигдах шаардлага, шинжилгээг хийх журам, шинжилгээний нарийвчилсан журам батлах эрх бүхий субъект зэргийг хуулийн төсөлд тодорхойлж өгсөн болно.

6.Хүрээлэн байгаа орчинд учирсан хохирол болон сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох үнэлгээг хийх эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх хүрээнд;

Шүүхийн шинжилгээний тухай хуульд эрүүгийн, иргэний, захиргааны, арбитраж болон зөрчлийн хэрэг, маргаанд хийгдэж байгаа зарим төрлийн шинжилгээний онцлогийн талаар тусгаагүй бөгөөд нийгмийн хөгжлийг даган хүрээлэн байгаа орчны болон сэтгэцийн хор уршиг тооцох зэрэг тусгай мэдлэг шаардагдах шинжилгээ, үнэлгээг хийх талаарх зохицуулалт байхгүй бөгөөд хуульд нарийвчлан тусгах шаардлага тулгарч байна.

Хүрээлэн байгаа орчны хохирлыг тооцох үнэлгээ, шинжилгээг Байгал орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу байгаль орчны үнэлгээний мэргэжлийн байгууллага хийж байгаа бөгөөд төрийн байгууллагаас энэхүү хохирлыг тооцоход их хэмжээний хөрөнгийг дээрх компаниудад төлдөг, тэр бүр үнэлгээний үр дүн бодиттой гарч чаддаггүй байна. Энэхүү байдал нь хүрээлэн байгаа орчны хохирлыг тооцох, энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэх, хүрээлэн байгаа орчныг нөхөн сэргээхэд хүндрэлтэй болдог.

Иймд хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг шүүх шинжилгээний байгууллага хийх, уг байгууллагын бүтцэд энэ төрлийн шинжилгээг хийх нэгжийг байгуулах, хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг хийх нийтлэг журам, тавигдах шаардлага, энэ төрлийн хохирлын үнэлгээг хийхэд баримтлах аргачлалыг батлах субъект зэргийг тодорхойлох зэрэг зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр заасан нь гэмт хэргийн улмаас хүний сэтгэл санаанд учирсан хор уршгийг арилгуулахаар шүүхэд гомдол гаргаж, шийдвэрлүүлэх эрх зүйн үндсийг зааж өгсөн байдаг. Гэвч эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдсэн Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуулиудад гэмт хэргийн улмаас хүний бие, эд хөрөнгөд учирсан бодит хохирол, гэм хорыг арилгах талаар зохицуулалтыг боловсронгуй болгосон боловч эдийн бус гэм хор тэр дундаа сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийн хэмжээг тогтоох, шүүхээр шийдвэрлүүлэх эрх зүйн орчин тодорхойгүй хэвээр байна.

Жишээ нь: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ” гэж заасан. Харин Иргэний хуулийн 230 дугаар зүйлд эдийн бус хохиролд хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд байхаар заасан боловч сэтгэл санааны хохирол, эсхүл сэтгэцийн хор уршгийг тодорхой зааж өгөөгүй байна.

Мөн Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус хохирлыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлж болохоор, мөн хуулийн 511 дүгээр зүйлд эдийн бус гэм хорыг зөвхөн хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд байхаар, түүнд учирсан гэм хорыг арилгахаар заасан байна. Харин Эрүүгийн хуульд “эрүүл мэндийн хохирол” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “сэтгэл санааны хохирол” гэж томъёолсон байдаг.

Дээрх зохицуулалтаас харахад гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд эдийн бус гэм хор учрахыг хүний сэтгэл санаанд хохирол, эсхүл сэтгэцэд учрах хор уршгийн алин болохыг нэр томъёоны хувьд нэг мөр тодорхойлоогүй болно.

Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд, сэтгэл санаанд буюу сэтгэцэд учирсан хор уршгийг хэрхэн ойлгох, ямар гэмт хэргийн улмаас хохирсон хохирлыг ямар шаардлагыг үндэслэн тооцох, ямар шалгуур үзүүлэлттэй байх зэрэг зохицуулалт байхгүй байна.

Ийнхүү эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч өөрт учирсан хохирлоо бодитой, бүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй байна.

Энэ нь нэг талаас Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн амь нас, эрүүл мэнд, сэтгэл санааны хохирол, эсхүл сэтгэцийн хор уршгийг тооцохдоо зөвхөн нотлох баримтад тулгуурлан эмчилгээ, оршуулга, тээврийн зардлын баримтыг харгалзан хохирлыг тооцож байна. Өөрөөр хэлбэл зөвхөн учирсан бодит хохирлыг шүүхээс тооцож байгаа бол эдийн бус хохирол болох сэтгэл санааны хохирол буюу сэтгэцийн хор уршгийг хэрхэн тооцох нь тодорхойгүй байгаагаас хохирлыг тооцолгүй орхигдуулж байна.

Нөгөөтээгүүр гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохирол буюу сэтгэцийн хор уршиг хүлээсэн этгээд нь өөрт учирсан сэтгэл санааны хохирлоо нэхэмжилдэггүй, шүүхэд гаргасан цөөн нэхэмжлэлийг шүүхээс хэрэгсэхгүй болгодог зэргээр хүний эрхийг бодитой эдлүүлэх боломжоор хангахгүй байна.

Монгол Улсын шүүхийн практикт гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохиролд буюу сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлбөр авсан кейс бусад хохирлыг нэхэмжилж шийдвэрлүүлсэн тохиолдлоос цөөн байдаг. Тухайлбал, нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн 2004 оны 970 дугаар тогтоолоор нэхэмжлэгчийн хууль бусаар хоригдсон хэрэгт хохирогчийн сэтгэл зүй, эрүүл мэндэд учирсан хохирлыг харгалзан 16 сая төгрөгийн нөхөн олговор олгохоор шийдвэрлэсэн байна. Мөн 2012 онд Баянгол дүүргийн шүүхээс ХБНГУ-ын эмчийн буруутай үйл ажиллагааны улмаас хөдөлмөрийн чадвараа 70 хувь алдсан хохирогчийн эрүүл мэндийн байдал, сэтгэл санаанд учирсан үр дагаврыг харгалзан сэтгэл санааны хохиролд 10 сая төгрөгийг тогтоож, буруутай этгээдээр гаргуулахаар шийдвэрлэсэн байдаг.

Харин гадаадын зарим өндөр хөгжилтэй орны хувьд сэтгэл санааны хохиролд буюу сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах гэмт хэргийн төрөл бүрээр тогтоосон тарифын үнэлгээг үндэслэн мөнгөн дүнгээр тооцож хохирогчид олгодог байна. Нөхөн төлбөрийг тооцохдоо “шударга болон үндэслэл бүхий байх”, “нөхөн төлбөрийн хэмжээ төлөгдөхүйц байх” зарчмыг баримтлан хохирол нь гэмт хэргийн хүнд, хөнгөнөөр хамааруулан түүний шууд хохирогчид болон шууд бусаар бусад этгээдэд учирсан, хохирлын шинж чанар, түр эсхүл байнгын шинжтэй сэтгэл санааны хохирол зэрэг нөхцөлүүдийг харгалзан улс бүр өөр өөрөөр тогтоож олгодог байна.

Хохирогчид олгох сэтгэл санааны хохирол буюу сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах төлбөрийн дээд доод хэмжээг мөн тогтоож өгдөг байна. Тухайлбал, Америкийн Нэгдсэн Улсад эмнэлгийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан сэтгэл санааны хохирлын хэмжээний дээд доод хэмжээ нь муж улсаас хамааран дунджаар 250 000 - 750 000 ам.долларт тогтоосон байдаг.

Түүнчлэн хохирогч нас барсан тохиолдолд сэтгэл санааны хохирлыг сэтгэл санааны хохиролд буюу сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах нөхөн төлбөрийг нэхэмжлэх, нөхөн төлбөрийг авах эрхтэй этгээдийг хуулиар хязгаарладаг байна. Тухайлбал, ХБНГУ-д хохирогч нас барсан тохиолдолд зөвхөн тодорхой төрлийн садан төрөл нь сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг авах бол Франц улсад өв залгамжлагч нь авах зохицуулалттай байна.

Иймд хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэргийг тогтоох, уг хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийг хэмжээг үнэлэх, шинжилгээ хийх талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд нэр томьёоны хувьд анагаахын шинжлэх ухааны нэр томьёог ашиглан “сэтгэцэд учирсан хор уршиг буюу гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн сэтгэцэд үзүүлсэн үр дагавар гэж томьёолж, энэ нь эдийн бус гэм хорд хамаарахыг хуульд тодотгон тусгаж, хохирогч энэхүү хохирлоо нэхэмжлэх эрхийг нарийвчлан тодорхойлсон болно.

Түүнчлэн дээрх хор уршгийг зэргийг тогтоох, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Эрүүгийн хуульд заасан бүх гэмт хэргийн бус тодорхой төрлийн зөвхөн хүний амь нас хохирох, бие эрхтэнд гэмтэл учрах, бэлгийн эрх чөлөөний эсрэг, ялгаварлан гадуурхалт, хүүхдийн эсрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг, эрүү шүлт тулгах, үндэслэлгүйгээр хорих, залилах, хулгай, дээрэмдэх, заналхийлэх гэх зэрэг нийт 14 бүлгийн 86 гэмт хэрэг байхаар тодорхойлж, Шүүх шинжилгээний тухай хуульд заасан бөгөөд уг хор уршгийн зэрэглэлийг шинжилгээний байгууллагаас тогтоож дүгнэлт гаргахдаа тухайн гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэцэд өөрчлөлт орсон байх, сэтгэцийн шинжилгээг хийлгэсэн байх, уг хор уршиг нь шууд, эсхүл шууд бус хохирогчид учирсан байх, түр зуурын, эсхүл байнгын шинж чанартай сэтгэцийн өөрчлөлт учирсан байх зэрэг нөхцөлийг харгалзан үзэх зохицуулалтыг төсөлд тусгасан.

Үүнээс гадна уг үнэлгээ шинжилгээг хийх аргачлалыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн сайд хамтран батлахаар, уг шинжилгээ үнэлгээнд тулгуурлан шүүхээс сэтгэцэд учирсан хор уршгийг тогтоох, нөхөн төлбөрийн жишиг хэмжээг Улсын дээд шүүхээс тогтоохоор төсөлд тусгасан болно.

Түүнчлэн Иргэний хуулийн 230 дугаар зүйлд эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд заасан тохиолдолд мөнгөн хэлбэрээр барагдуулж болохоор заасантай уялдуулан Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт шүүх хор уршгийг арилгах, нөхөн төлөх төлбөрийг мөнгөн дүнгээр тооцох зохицуулалтыг оруулахаар хуулийн төслийг боловсруулсан. Үүнээс гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1, 45.4 дүгээр зүйлд хохирогч сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлбөр авах эрхтэй болохыг зааж уг нөхөн төлбөр авах зохицуулалтын хүрээнд төлөх төлбөрийн хэмжээг эрүүгийн хэрэг хэлэлцэх ажиллагааны явцад тогтоох, эсхүл хохирогч хохирлоо нэхэмжлээгүй, эсхүл хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулахгүйгээр нэхэмжлэлийн тооцоог гаргах боломжгүй тохиолдолд иргэний шүүхээр шийдвэрлүүлж болох нөхцөлийг нарийвчлан тусгасан.

Харин сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлэх мөнгөн хэлбэрээр арилгах, нөхөн төлүүлэх зохицуулалттай уялдуулан Иргэний хуулийн 511 дүгээр зүйлд нөхөн төлбөрийг гэм хор учруулагч арилгах үүрэгтэйг зааж, нөхөн төлбөрийн тооцоход гэмт хэргийн улмаас өнчирсөн бага насны хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлбөрийн хэмжээг насанд хүрсэн хүнийхээс 2 дахин илүү хэмжээгээр тооцохоор, нас барсан хүний гэр бүлийн гишүүнд олгох хохирлын хэмжээг тогтоохдоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр,

эсхүл нас барсан хүний нас, хүн амын дундаж наслалтын зөрүүг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр үржүүлэн хохирогчид аль ашигтайг шүүхээс сонгох байдлаар тогтоож болох зохицуулалтыг тусгасан болно.

Дээрх нөхцөлөөс гадна хуулийн төсөлд хохирогч нь нас барсан тохиолдолд сэтгэцийн хор уршгийн нөхөн төлбөрийг тухайн хохирогчийн гэр бүлийн гишүүд, эсхүл гэр бүлийн гишүүн нь эрх зүйн чадамжгүй бол хууль ёсны асран хамгаалагч нь нэхэмжлэл гаргаж болох зохицуулалтыг тусгаад байна.

-Шүүх эмнэлгийн төлбөртэй явуулж байсан шинжилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх, төрийн байгууллагаас үзүүлсэн үйлчилгээнд улсын тэмдэгтийн хураамжийг авах зохицуулалтын хүрээнд;

Шүүх эмнэлгийн зарим шинжилгээг төлбөртэй хийхээр журамлан явуулж байсан боловч уг журам нь Захиргааны ерөнхий хуультай нийцэхгүй байсан бөгөөд Захиргааны хэргийн шүүхээс хүчингүй болгосон байдаг.

Иймд хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцүүлэн шүүх эмнэлгийн шинжилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх, шүүхийн шинжилгээний байгууллагаас иргэдэд үзүүлсэн зарим үйлчилгээнд улсын тэмдэгтийн хураамжийг тогтоох зохицуулалтыг ялгамжтайгаар шинээр тусгасан болно. Тухайлбал, гадуур хийгдэх шинжилгээнд шинжилгээний эрх авахад 500 000 - 800 000 төгрөг, ДНХ-ээр эцэг, эх тогтоох лабораторийн шинжилгээ хийхэд 120 000 -180 000 төгрөг, хүний цусны бүлэг тогтоох шинжилгээ хийхэд 3 000 - 8 000 төгрөгийг хураамжтай байхаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулаад байгаа болно.

-Шүүх шинжилгээний байгууллага, түүний тогтолцоо, шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн байдлыг шинээр томъёолон оруулж, алба хаагчийн баталгааг нарийвчлан тодорхойлох хүрээнд;

Үүнээс гадна хүн ам, гэмт хэргийн өсөлт, шинжилгээний онцлог, цар хүрээ, тоо хэмжээ зэргийг харгалзан шинжилгээний байгууллагыг Засгийн газрын агентлагийн статустай болгож, бүтэц, орон тоог шинэчлэн тогтоох, шүүхийн шинжилгээний алба хаагчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, тэдгээрийн нийгэм, улс төр, хууль зүй, аюулгүй байдлын баталгаа, хараат бус байдлыг хангах зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгасан.

Дээрх зохицуулалтыг тусгахдаа шүүх шинжилгээний байгууллагын алба хаагч нь төрийн тусгай албан хаагч болохын хувьд төрийн тусгай албан хаагчийн нийтлэг зохицуулалт, цагдаагийн, цэргийн алба хаагчтай адилтган нарийвчилсан зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан болно. Тухайлбал, шинжилгээний байгууллагын алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн холбогдох зохицуулалтаар зохицуулах бол, бусад алба хаагчийг томилох, чөлөөлөх, цол олгох, баталгаа, сахилгын шийтгэл оногдуулах, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх, аюулгүй байдал, дайчилгаатай холбоотой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, үр нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна:

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон шүүх шинжилгээ хийх үйл ажиллагаа нь цогц байдлаар зохицуулагдах бөгөөд шүүх шинжилгээний байгууллага болон хууль сахиулах байгууллагуудын уялдаа холбоо сайжирна;

-Шүүх шинжилгээний хараат бус байдал, ил тод ажиллах зарчим, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх, шүүх шинжилгээний үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, шинжээч, мэргэжилтэн үйл ажиллагаандаа шинжлэх ухаанч байдлаар хандах хандлага дээшилнэ;

-Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдаж байгаа шинжээч, мэргэжилтний эрх, үүргийг Шүүх шинжилгээний тухай хуулиар нэгтгэн нарийвчлан тогтоосноор шүүхийн шинжилгээний чанар сайжирна;

-Шүүх шинжилгээ хийх хугацааг жишиг хугацааг үндэслэн тогтоосноор шинжээчийн нэгж шинжилгээнд зарцуулах хугацаа багасах, шинжилгээ хийх хугацаа тодорхой болох, шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой шинжлэх ухааны үндэслэлтэй хийх боломж бүрдэж, шинжилгээний үр дүн бодитой болоход нөлөөлнө;

-Шүүх шинжилгээний байгууллага Хөрөнгийн үнэлгээнд хийх шинжилгээ, Инженер-техникт хийх шинжилгээ болон Хүрээлэн буй орчинд учирсан хохирол тогтоох шинжилгээг хийснээр урьд энэ төрлийн шинжилгээг хийхэд шаардагддаг байсан зардал буурах боломж бүрдэнэ;

-Шүүх шинжилгээний байгууллагын даргын шийдвэрээр Шүүх шинжилгээний байгууллагаас бусад этгээдэд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсоноор нэгдсэн бүртгэл, хяналт, шинжээчийн үйл ажиллагаанд ашиглагддаг техник, тоног төхөөрөмжийн стандарт, шинжилгээний чанар, шүүх шинжилгээний үнэлэмж сайжирна;

-Шүүх эмнэлгийн шинжилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх зохицуулалтыг бий болгосноор гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн шүүх эмнэлгийн шинжилгээний төлбөрийн дарамтыг арилгана;

-Шүүх шинжилгээний тухай хуулиар шүүх шинжилгээний хэлбэр, зарим төрлийн шинжилгээний онцлог, шүүхийн шинжилгээний оролцогчийн эрх, үүрэг, шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо, шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал тодорхой болох, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх боломж бүрдэнэ;

-Шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо боловсронгуй болж, хэрэгцээ шаардлагад нийцсэн чиг үүргийг хэрэгжүүлэх боломж бүрдэхийн сацуу шинжилгээний зардал, байгууллагын төсөв, санхүүжилт, албан хаагчийн улс төр, хууль зүй, нийгэм, эдийн засаг, аюулгүй байдал болон бусад баталгаа тодорхой болж, алба хаагчид тавигдах мэргэжлийн болон боловсрол, ур чадвар, мэдлэгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, алба хаагчийг давтан сургах, сонгон шалгаруулалтыг явуулснаар хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ахиц гарна гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг улсын төсвөөс нэмж санхүүжүүлэх шаардлагатай.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 11 бүлэг, 81 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Шүүхийн шинжилгээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хууль, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, тогтоолын төслийг тус тус боловсруулав.

Шүүх шинжилгээний тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/ төсөл болон дагах хуулийн төсөлд Засгийн газрын гишүүд болон холбогдох төрийн байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээдээс саналыг авч, зарим саналыг хуулийн төсөлд тусгасан болно.

-----oOo-----